



НОЁДЫН ТУУРЬ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Н.АРИУНБОЛДОД

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,  
Утас/Факс: 7036-3695  
E-mail: p\_se@inspection.gov.mn

2022.02.23

№

18-03-034/22

Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт  
хийсэн тухай

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.1.2 дахь заалт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар”-ыг тус тус үндэслэн “Барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн хяналт хийж дүгнэлт гаргах тухай” 01/16 дугаартай удирдамжийн дагуу Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч У.Энхбат Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд баригдах соёлын төвийн барилгын ажлын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:

Барилга байгууламжийн эскиз, ажлын зураг төслийг “Ноёдын туурь” ХХК-д боловсруулж захирал Н.Ариунболд, архитектор Д.Дамдиндорж нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Тус аж ахуйн нэгж нь Барилга, хот байгуулалтын яамны 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ЗТ37-508/19 дүгээр тусгай зөвшөөрөлтэй байна. Ажлын зургийн шифр НТ-01/2022.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/15 дугаар захирамжаар 432 метр квадрат газрыг урлаг, соёлын байгууллагын зориулалтаар 10 жил эзэмшүүлэхээр шилжүүлж, нийт 2000 метр квадрат газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх эрхийн Э-1314000313 бүртгэлийн дугаар бүхий 0000025068 дүгээр гэрчилгээг олгосон.

Зураг төслийн товч агуулга: Төлөвлөж буй соёлын төвийн барилга нь тэнхлэгээрээ 42.00x23.50 метр хэмжээтэй, 2 давхар барилга.

Нэгдүгээр дүгээр давхарт үүдний хэсэг, тасалбар түгээх хэсэг, камер хяналтын өрөө, хувцасны өлгүүрийн өрөө, буфет, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөө, техникийн 2 өрөө, тайз заслын өрөө, үзвэрийн танхим, тайз, эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө, хувцас солих өрөөний эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, шатны хонгил, зөөврийн цахилгаан үүсгүүрийн өрөө зэрэг төлөвлөсөн.

Хоёрдугаар давхарт багш нарын өрөө, гэрлийн удирдлагын өрөө, номын сан, шатны хонгил, музейн 2 өрөө, эрхлэгчийн өрөө, зургийн дугуйлангийн өрөө, дуу бичлэгийн өрөө, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, венткамерийн өрөө, бельэтаже зэрэг төлөвлөсөн.

Ус хангамж, ариутгах татуурга: “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ-ын дарга А.Алтансүх, цэвэр усан хангамжийн инженер А.Алтанзулын гарын үсгээр баталгаажсан 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 69 дүгээр техникийн нөхцөлтэй, бохир усны хэсгийн зохион

00000015

байгуулалттай байхаар төлөвлөсөн боловч ариутгах татуургын гадна холболтын зураг тусгагдаагүй.

Дулаан хангамж: “Хүдэр дулаан” ХХК-ийн захирал О.Оюунцэцэгийн гарын үсгээр баталгаажсан 01 дүгээр техникийн нөхцөлтэй.

Цахилгаан хангамж: “ДСЦТС” ХК-ийн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Батжаргалын гарын үсгээр баталгаажсан 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 22020002 дугаар цахилгааны техникийн нөхцөлтэй.

Инженер геологийн судалга: Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар болон “Энх-Өрнөлт” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэсэн, төлөвлөж буй барилгын талбайн суурийн катлованыг нээхдээ инженер геологийн зохиогчийн хяналт хийлгэх шаардлагатай гэж дурдсан байна.

ДҮГНЭХ НЬ:

Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд баригдах “Ноёдын туурь” ХХК-ийн боловсруулсан соёлын төвийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл нь Монгол Улсын Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-д заасан эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна.

Ажлын зураг төсөлд ус хангамж, ариутгах татуурга, цахилгааны гадна холболтын зураг тусгагдаагүй болно.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д тусгагдсаны дагуу дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН  
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:  
ЗАХИРАЛ

У.ЭНХБАТ

Н.АРИУНБОЛД

